

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2020 ОНЫ 10 ДУГААР САРЫН МЭДЭЭ

2020 оны 10 дугаар сарын 28

Дархан-Уул аймаг

1. Удирдлага, зохион байгуулалтын талаар

Аймгийн шуурхай хурал энэ сард нийт 4 удаа хуралдаж цаг үеийн байдалтай холбоотой 21 асуудлаар аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлагууд, төрийн болон төсвийн байгууллагын удирдлагуудад чиглэл өгөн ажиллан, аймгийн Засаг даргын зохион байгуулалтын 35 захирамж гарч удирдлага, арга зүйгээр ханган ажилласан байна.

Дархан-Уул аймгийн нутгийн захиргааны байгууллага нь иргэдийн өргөдөл, гомдол, санал, хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэхдээ “Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг хянан шийдвэрлэх тухай” хууль, Засгийн газрын 2005 оны 67 дугаар тогтоол, 2007 оны 8 дугаар албан даалгавар, аймгийн Засаг даргын 2018 оны 01-А/266 дугаар захирамжаар батлагдсан “Дархан-Уул аймгийн нутгийн захиргааны байгууллага албан тушаалтанд иргэдээс гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх журам” болон холбогдох бусад хууль, эрх зүйн актуудыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон хэрэгжүүлж сум, хэлтэс, агентлагууддаа мэргэжил, арга зүйн удирдлагаар ханган улирал бүр үнэлэлт, дүгнэлт өгч ажиллаж байна.

Аймгийн хэмжээнд нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтанд хандаж иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг дараах эх үүсвэрээр хүлээн авч байна. Үүнд:

1. Аймгийн нутгийн захиргааны байгууллагуудаар;
2. “Нийтийн үйлчилгээний нэгдсэн төв”-ийн 70371212 дугаарын нээлттэй утсаар;
3. Дархан сумын “Иргэдэд үйлчлэх төв”-ийн 70371313 дугаарын утсаар;
4. www.darkhan.gov.mn, Smartdarkhan цахим хуудсаар;
5. Аймгийн болон сумдын ЗДТГ-ын “Иргэд хүлээн авах өрөө”-өөр;
6. Засгийн газрын “11-11 төв”-өөр тус тус өргөдөл, гомдлыг хүлээн авч байна.

2020 оны 3 дугаар улиралд Дархан-Уул аймгийн нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтанд хандаж 11087 өргөдөл, гомдол ирүүлснээс 10389 өргөдөл, гомдлыг шийдвэрлэж, 698 өргөдөл, гомдлын шийдвэрлэх хугацаа болоогүй байна. Өргөдөл, гомдлын шийдвэрлэлт 93.7 хувьтай, нийт ирүүлсэн өргөдөл, гомдлоос 10149 хүсэлт, 216 санал, 722 гомдол тус тус эзэлж байна. Иргэд ихэвчлэн тухайн байгууллагаас үзүүлдэг төрөлжсөн үйлчилгээ, газар хүссэн болон нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагдахыг хүссэн тухай өргөдөл ирүүлсэн байна.

Аймгийн Засаг даргын Тамгын газарт 554 өргөдөл, гомдол ирүүлснээс 517 иргэний өргөдөл, гомдлыг шийдвэрлэж, 37 иргэний өргөдөл, гомдлыг шийдвэрлэх хугацаа болоогүй өргөдөл гомдлын шийдвэрлэлт 93.3 хувьтай байна. Өргөдөл, гомдлын мэдээг улирал бүр www.darkhan.gov.mn сайтад байршуулан ажиллаж байна.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар Төрийн дээд одон, медалиар шагнуулсан 205 иргэний шагнал гардуулах хүндэтгэлийн арга хэмжээг Дархан-Уул аймгийн Залуучууд театрт 2020 оны 10 дугаар сарын 13-ны өдөр зохион байгуулж Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын Удирдлагын хэлтсийн дарга шагналыг гардууллаа.

Мөн Дархан хотын 59 жилийн ойн Баярын хурлын арга хэмжээнд аймгийн Хүндэт иргэнээр аймгийн Засаг дарга асан 2012-2020 онуудад Улсын Их Хурлын гишүүнээр ажиллаж байсан Дамдины Хаянхарвааг өргөмжиллөө.

Дархан хотын “Хүндэт дэвтэр” нь 1963 оноос хойш 57 дахь жилдээ хөтлөгдөж ирсэн бөгөөд аймаг орон нутгийн ололт амжилт, хөгжил цэцэглэлт, бүтээн байгуулалтад үнэтэй хувь нэмэр оруулсан нийгэм, эдийн засаг, соёл, урлагийн салбарын 177 иргэдийг “Хүндэт дэвтэр”-т бичиж алдаршуулсан байна. Дархан хотын 59 жилийн ойн баярыг угтаж Дархан-Уул аймгийн Дархан Төмөрлөгийн үйлдвэрийн ахмад “Аж үйлдвэрийн гавьяат ажилтан” Давхарын Гончигсүрэн, Энх Түшээ ахмадын хорооны дарга Халзангийн Бааст, Дархан-Уул аймгийн Засаг даргын Тамгын газрын ахмад настан Аварзэдийн Ичинхорлоо нарын нэрийг аймгийн “Хүндэт дэвтэр” бичиж алдаршууллаа.

2. Эдийн засгийн бодлогын хүрээнд:

Татвар төлөлт, төсвийн орлого бүрдүүлэлтийн талаар :

Татвар төлөгчдийн баазыг бичил, жижиг гэсэн 2 сегментэд хуваан эдийн засгийн байдал, бизнесийн үйл ажиллагаа, татвар төлөгч бүрийн онцлог, чиглэлийг хандлагын түвшин буюу төлөлт, ногдуулалт, тайлагналтын түвшинд урьдчилан тооцож судалгааны үндсэн дээр харилцан тохирсон процесс үйл ажиллагааг хийж байгаагаас орлогын төвлөрүүлэлт, өрийн барагдуулат сайжирч байгаа.

Сангийн Сайдын өгсөн чиглэлийн хүрээнд ТЕГ-ийн даргын өр, ногдлыг өнөөдрийн байдлаар нь барагдуулж, энэ жилийн төсвийн жилд төсөвт оруулах үүргийн дагуу ТЕХ-иар хүлээсэн бүх л үүрэг, эрхийг хэрэгжүүлэн ажиллаж байна. Нийт дунд сегментийн 19, жижиг сегментийн 31 татвар төлөгч, шүүхийн шийдвэрээс барагдахгүй буцаж ирсэн 1,5 тэрбум төгрөгийн өр зэрэг дээр процесс ажиллагааг хийж, хөрөнгө тогтоох, дуудлага худалдаа хийх, бэлэн мөнгө хураах, мөнгөн хэлбэрт шилжүүлэх тал дээр дотоодод хандсан шинэ хуулийн сургалтыг хийж, Монгол алтан тос, Шарын гол ХК зэрэг нийт 54 газарт мэдэгдэж, төсөвт 600,0 сая төгрөгийг төвлөрүүлсэн.

НӨАТУС буюу и-баримтыг хамгийн их бараа ажил үйлчилгээ явагдаж байдаг бөөний төвүүд болон төвлөрсөн захууд, худалдааны төвүүдийн иргэн, хуулийн этгээд олгохгүй байгаа байдлыг хялбаршуулан систем болох QR код дата унахгүйгээр гар утсаараа 2-3 минутын дотор харилцан ибаримт илгээн, баталгаажуулах ажлын хүрээнд хэвлэгдсэн ирсэн 647-н наалтаас энэ 7 хоногт 162 наалтыг татвар төлөгчдийн ажлын байранд байршуулан татвар төлөгчдөд зөвлөгөө өгч ажилласан байна. Өссөн дүнгээр нийт 405 татвар төлөгч QR код уншуулан эцсийн хэрэглэгч болон бизнес эрхлэгчдэд баримт өгөх боломж бүрдээд байна.

Санхүүгийн хяналт шалгалтын чиглэлээр:

Санхүүгийн хяналт, аудитын алба нь 2020 оны санхүүгийн хяналт шалгалтын төлөвлөгөөний дагуу 2018-2020 оны эхний хагас жилийг дуусталх хугацааны санхүүгийн үйл ажиллагааны баримтын шалгалтыг хийж 26 дугаар цэцэрлэгт 1,6 сая төгрөг, 27 дугаар цэцэрлэгт 1,3 сая төгрөг, 21 дүгээр цэцэрлэгт 0,3 сая төгрөг, 18 дугаар цэцэрлэгт 0,5 сая төгрөг нийт 3.7 сая төгрөгийн Улсын ахлах байцаагчийн акт тогтоолоо.

Захиргааны ерөнхий хуулийн дагуу төлөвлөгөөт хяналт шалгалтын явцад холбогдох ажилтан, мэргэжилтнүүдтэй уулзан “Сонсох ажиллагаа”-г зохион байгуулж ажилласан.

Санхүүгийн хяналт шалгалтын улсын байцаагчдын тогтоосон актаар орон нутгийн төсөвт 89,0 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна. Актын төлбөрийн үлдэгдэлтэй байгууллагуудын төсвийн шууд захирагч, нягтлан бодогч нарт актын төлбөрийн үлдэгдлийг барагдуулахыг анхаарууллаа.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн талаар

Орон нутгийн болон тусгай зориулалтын шилжүүлгээр санхүүжих байгууллагын төсвийн гүйцэтгэлийн 2020 оны 09 дүгээр сарын мэдээг боловсруулж, нэгтгэн Сангийн яам, аймгийн цахим хаяг <http://darkhan.gov.mn>, АЗДТГ-ын төсөв санхүүгийн ил тод байдлын самбарт тус тус байршуулж, төсвийн ил тод байдлыг хангаж ажилласан.

2020 оны 09-р сарын төсвийн гүйцэтгэлийн мэдээгээр орон нутгийн төсвийн орлого 23,200,4 сая төгрөг төвлөрөхөөс 22,334,0 сая төгрөг төвлөрч орлогын төлөвлөгөө 96.3 хувь буюу 866.4 сая төгрөгөөр тасарсан байна.

Мэдээгээр зарлага санхүүжилтийн хувьд 79,515.9 сая төгрөг зарцуулахаас 67,076.9 сая төгрөг зарцуулжээ.

Мөн аймгийн хэмжээнд 9 дүгээр сарын байдлаар 2,176.8 сая төгрөгийн авлагатай, 696.0 сая төгрөгийн өглөгтэй гарсан бөгөөд өр төлбөрийн 43.3 хувийг цалин, НДШ, 1.4 хувийг тогтмол зардал, 55.3 хувийг бараа үйлчилгээний бусад зардал эзэлж байна.

Сангийн яам, төсөв санхүүгийн тогтвортой байдлыг бэхжүүлэх төслөөс УСНББОУС-ын сургалтыг 2 өдөр амжилттай зохион байгууллаа. Тус сургалтад төсвийн байгууллагын 130 нягтлан бодогчид хамрагдсан бөгөөд сургалтаар нягтлан бодогчид стандартын өөрчлөлт, хэрэглээний тухай мэдлэг олгохоос гадна аудитын зөвлөмжийг хэрэгжүүлэх, үндсэн хөрөнгийн дахин үнэлгээ, нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг боловсруулахтай холбоотой тулгамдсан асуудлаар санал солилцлоо.

3. Хууль, эрх зүйн бодлогын хүрээнд:

Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тогтоол 3, аймгийн Засаг даргын захирамж 12, Засаг даргын Тамгын газрын даргын тушаал 18, гэрээ 5 үндэслэлийг хянаж зөвлөгөө өгч, Захирамж, тушаалд ашиг сонирхлын зөрчилгүй мэдүүлэг гаргах шаардлагатай эсэхийг шийдвэрлэсэн Мөн. албан тушаалтнаас гаргасан ашиг сонирхлын зөрчилгүй 22 мэдэгдэл тайлбарыг АТГ-ын МБП-д шивж оруулан, нэг албан тушаалтны хөрөнгө орлогод их хэмжээний өөрчлөлт орсныг бүртгэлээ.

Төрийн мэдээлэл сэтгүүлийн 2018 оны 5 дугаарт нийтлэгдсэн Төв банкны тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай, Төрийн албаны тухай, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай, Хэлэлцээр гэрээ соёрхон батлах тухай хуулиудын нийт 61 заалтад кодвикаци хийсэн. Олон улсын "Охидын эрхийг хамгаалах өдөр"-ийг угтан өсвөр насны охидыг чадавхижуулах сургалт, хэлэлцүүлгийг удирдамжын дагуу аймгийн Мэдээлэл технологийн алба, Хүний эрхийн үндэсний комиссын Дархан-Уул аймаг дахь ахлах шинжээч, Дархан мэтгэлцээний танхим, аймгийн Эрүүл мэндийн газар, Аймгийн Цагдаагийн газар, Боловсрол, соёл, урлагийн газартай хамтран зохион байгууллаа. Сургалтанд 12 сургуулийн нийт 300 орчим сурагч охид хамрагдсан байна.

АТГ-аас ирүүлсэн зөвлөмжийн хэрэгжилтийг гаргуулан авах ажлын хүрээнд 4 сумын ЗДТГ, аймгийн ЗДТГ-ын ХОХБТХ, НҮА, ТЗУХ -ын холбогдох албан тушаалтанд зөвлөмжийн заалтыг хүргүүлж биелэлтийг гаргаж 2020.10.23-ны өдрийн дотор ирүүлэхийг мэдэгдэн ажиллаж, АТГ-ын даргын 2018 оны 123 дугаар тушаалын хэрэгжилтийг хангуулах ажлын хүрээнд Дархан-Уул аймгийн ЗДТГ-ын албан тушаалтнаас 2019 он, 2020 оны эхний 9 сарын байдлаар Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийг зөрчсөн, сахилгын шийтгэл ногдуулсан тохиолдол байхгүй тухай албан бичгийг АТГ-т хүргүүллээ.

Архивын тасгаар давхардсан тоогоор 123 иргэний хүсэлтийг хүлээн авч тушаалын хуулбар-88, тодорхойлолт-69, цалингийн лавлагаа-1, нийт 158 лавлагаа гарган гарган ажилласан.

4. Нийгмийн бодлогын хүрээнд:

Дархан хотын 59 жилийн ойн өдрийг тохиолдуулан дараах ажлуудыг зохион байгуулсан. Үүнд:

- Дархан нутгийнхаа газар усны түүх, домог, дурсгалт газруудаар танилцах зорилгоор "Миний Дархан-59" аяллыг Дархан сумын 14 сургуулийн Түүх-Нийгмийн ухааны 50 багш, УБ-аас ирсэн 2 зочин багшийн хамтаар автобустай аялал зохион байгууллаа.
- Хотын өдрөөр аймгийн ерөнхий боловсролын 27 сургууль, 38 цэцэрлэгийн сурагч хүүхдүүд "Хамгийн сайхан хот" дууг анги бүлгээрээ, сургуулиараа дуулж мэндчилгээ дэвшүүлсэн. Энэ ажил 3 дахь жилдээ уламжлал болгон зохион байгуулагдаж байна.

- “Хамгийн сайхан хот” дууны хөшөөнд хүндэтгэл үзүүлж цэцэг өргөх ёслолын үйл ажиллагааг зохион байгууллаа. Цэцэг өргөх ёслолд Дархан-Уул аймгийн шилдэг тэргүүний сурагчид, тамирчид, залуу ахмад үеийн төлөөлөл, аймаг орон нутгийн удирдлагууд, Дархан хотын үе үеийн удирдлагууд оролцлоо.

- Аймгийн Төв номын сангаас “Номтой өдөрлөг”-ийг зохион байгуулсан.

- Хотын өдрийн баярын хурлын хүндэтгэлийн концертыг Залуучууд театр нь гавьяат жүжигчид болон яруу найрагчид, мэргэжлийн урлагийн 53 уран бүтээлчдийг хамруулсан бүрэн хэмжээний урлагийн тоглолтыг зохион байгуулсан.

Аймгийн музей Дархан хотын 59 жилийн ойг тохиолдуулан гэрэл зургийн үзэсгэлэнг Залуучууд Театрт олон нийтэд толилууллаа.

Эцэг эхийн оролцоо, санаачлагыг нэмэгдүүлэх зорилгоор “Дархан-444” хөтөлбөрийн хүрээнд эцэг, эхийн сургалт, зөвлөгөөнийг 2020 оны 10 дугаар сарын 22 өдөр ГБХЗХГ, Цагдаагийн газар, Гүүд нэйборс олон улсын байгууллагуудтай хамтран зохион байгуулсан. Сургалт зөвлөгөөнд 21-н сургуулийн 16 нийгмийн ажилтан, 9-р ангийн хүүхэдтэй 246 эцэг, эх оролцлоо. /ковидын зөвлөмжийн дагуу зөвлөгөөнд оролцогчдын халуун хэмжиж, гарыг ариутгаж оролцуулсан/

“Монгол бичгийн үндэсний хөтөлбөр”-ийн хүрээнд Дархан хотын иргэн бүрт монгол хэл, бичгийг эзэмшүүлэх зорилгоор “Миний нэрийн хуудас–Нэр төрийн баталгаа” 2 сарын аяныг зохион байгуулан ажилласан.

Сургуулийн өмнөх боловсролын байгуулага буюу цэцэрлэгүүдэд нэмэлт элсэлт зохион байгуулсаны улмаас статистик мэдээг дахин авч нэгтгэхэд СӨБ-ийн нийт хүүхдийн тоо 7848 болж 250 хүүхдээр нэмэгдлээ. БСУГ судлагдахуун хариуцсан 13 мэргэжилтэн зөвлөн туслах ажлаар 8 цэцэрлэг, 19 сургуулийн 115 багшийн хичээлд сууж мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллаа.

АНУ-ын ЭСЯ-аас зохион байгуулдаг Сайн дурын ажилтантай хамтран ажилладаг хөтөлбөрийг хариуцсан Захирал Гревер Эйнсворт, Төвийн бүсийн ахлах Г.Баярсайхан, Д.Зоригтбаатар нар Дархан-Уул аймагт ирж Америкаас ирэх сайн дурын ажилтануудтай хэрхэн ажиллаж болох боломж талаар БСУГ-ын дарга, сургуулийн удирдлага холбогдох мэргэжилтнүүдтэй уулзалт зохион байгууллаа.

2020 оны 10-р сарын 24-ны өдөр “Боловсрол ба технологи” Багш нарын VII бага хурал Дархан хотод зохион байгуулагдлаа. Бага хурлыг Монгол-Германы хамтарсан ашигт малтмал, технологийн их сургууль. Боловсрол, соёл урлагийн газар, Дархан сумын 1 дүгээр сургуулиуд хамтран зохион байгуулж БСУГ-ын мэргэжилтнүүд болон ЕБС-ын багш ажилчид хамрагдсан.

Эрүүл мэндийн чиглэлээр:

Эрүүл мэндийн яамнаас 2020.09.28-2020.11.30-ны өдрийн хооронд 3 сарын хугацаатай “Эерэг хандлага-Эмчилгээний эхлэл аян”-ыг аймаг орон нутагт зохион байгуулж ажиллах үүрэг чиглэл өгсөнтэй холбогдуулан аймгийн эрүүл мэндийн байгууллагууд, үйлдвэрчний эвлэл хороо олон талт арга хэмжээнүүдийг санаачлан зохион байгуулж байна.

Дархан-Уул аймгийн хэмжээнд зохион байгуулж байгаа Томуугаас сэргийлье уриан дор Дархлаажуулалтын 10 хоног аян нь томуугийн вакцинд нийт-11.240 хамрагдахаас 9820 хүн хамрагдаж 87.3%-тай байна. ЕБСургуулийн 7-15 насны хүүхдийн сахуу татрангийн 2-т вакцинаар 4200 хамрагдахаас 2900 хүүхэд хамрагдаж 85%-тай хийгдсэн. Мөн 2-5 нас 7100 хамрагдахаас 5160 ахмад жирэмсэн 3510 хамрагдахаас 3,509,эмнэлгийн ажилчид 630 хамрагдахаас 631 хамрагдсан сайн дураар 250 хүн тус тус хамрагдсан байна.

Цэрэг татлага 2020 оны 10 дугаар сарын 5,6,7-ны өдрүүдэд Орхон, хонгор, шарын гол суманд зохион байгуулж 18-25 насын 310 залуучууд хамрагдсан.

Шинэ захын нийтийн үйлчилгээний нэгдсэн төвөөр үйлчлүүлж байгаа “COVID-19” урьдчилан сэргийлэх мэдээлэл 1442 иргэдэд өгч, зай барих, агаар сэлгэлт хийх, дархлаагаа дэмжих, гараа угаах, халдваргүйжүүлэх, маскаа зүүх, гэр орондоо цэвэрлгээ, халдваргүйтгэл хийх, хоолой зайлах аргачлал зөвлөгөөг 1909 хүнд зөвлөгөө өгсөн.

Нийтийн үйлчилгээний нэгдсэн төвөөр:

- Нийт-2173 хүнд үйлчлүүлсэн.
- Артерийн даралт-358 өөрчлөлттэй-87
- Сахар-10 өөрчлөлттэй-3 БЖИ-43 өөрчлөлттэй-21
- Өндөр -43
- Биеийн жин-43
- Бусад зөвлөгөө нийт- 2173 хүнд өгсөн.

Эрүүл мэндийн байгууллагууд Коронавируст халдвараас “COVID-19” урьдчилан сэргийлэх мэдээлэл сурталчилгааг Эрүүл мэндийн байгууллага болон худалдаа үйлчилгээний газруудын үйлчлүүлэгчид, иргэдэд нийт 36225 хүнд мэдээлэл, зөвлөгөөг өгч Эрүүл мэндийн яам, Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвийн боловсруулсан 8 төрлийн 7410ш зөвлөмжийг иргэдэд тараасан. Эрүүл мэндийн байгууллагууд цахим хуудсанд 10 төрлийн зөвлөмж, 5 төрлийн шторк байршуулж, хандсан хүний тоо 102386 байна.

Аймгийн нэгдсэн эмнэлэг нь:

- Нийт үзлэг- 12329 үүнээс
- урьдчилан сэргийлэх 1996 / 30.8% / үзлэг байна.
- Ор хоногийн гүйцэтгэл -7960 байна. эмчлэгдсэн өвчтөн-8272.5
- эмнэлгийн нас баралт 13-тох /1.1%/ үүнээс нярайн нас баралт- 0
- Яаралтай дуудлагын утсанд нийт -789 дуудлага хүлээн авсан байна.
- Нийт төрөлт-173 байна.

Цахимаар үйлчлүүлсэн үйлчлүүлэгч – 13365

- Утас- 1708
- Халуун үзсэн- 12606
- Аудио сургалт- 328
- Шинжилгээний хариу тараасан -11 518
- Covid-19н сургалт мэдээллийг үйлчлүүлэгчидэд тогтмол хүргэж байна.

Хөдөлмөр эрхлэлт, халамжийн үйлчилгээний чиглэлээр:

Нийгмийн халамжийн 6 төрлийн үйлчилгээ цахим хэлбэрт шилжлээ. Хөдөмөр, нийгмийн хамгааллын яам, Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй ажлын хүрээнд нийгмийн халамжийн 6 нэр төрлийн тэтгэвэр, тэтгэмжийг цахим хэлбэрт шилжүүлэх ажил тус сард хийгдэж бүрэн шилжлээ. Дархан-Уул аймгийн хэмжээнд Цалинтай ээж – **4720**, жирэмсэн эхийн тэтгэмж – **785**, Эхийн алдар одонгийн тэтгэмж – **6148**, Насны хишиг – **4868**, өрхи толгойлсон эцэг, эхэд олгох мөнгөн тэтгэмж – **190**, ихэр хүүхдийн мөнгөн тэтгэмж – **37** иргэн тус тус цахимаар /E-halamj/ үйлчилгээнд хамрагдаад байна.

“Ахмадын хөгжлийн төв” ахмадад үйлчилгээ үзүүлж эхэлсэн. Тус сард Улсны төсвийн 1,6 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар 2019-2020 онд баригдсан “Ахмад настны хөгжлийн төв” үүд хаалгаа нээж, нээлтийн үйл ажиллагаа зохион байгууллаа. Тус төвөөр өнөөдрийн байдлаар давхардсан тоогоор 400 орчим ахмад настан үйлчлүүлээд байна.

Хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнд 7726 иргэн хамрагдаж байна. Дархан-уул аймгийн хэмжээнд тус сард 1342 өрхийн 3835 том хүн, 3891 хүүхэд хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнд хамрагдаж 153'8 сая төгрөгийн хүнсний 10 нэр төрлийн бүтээгдэхүүнийг гэрээ байгуулан ажиллаж буй 19 хүнсний дэлгүүрээр олгосон байна.

Өрхийн мэдээллийн нэгдсэн санд шинээр төрсөн 39 хүүхдийг бүртгэлээ. Өрхийн мэдээллийн нэгдсэн санг баяжуулах, өрхийн амьжиргааны түвшин тодорхойлох судалгаанд дахин болон шинээр хамрагдах хүсэлт гаргасан 98 өрхийн өргөдлийг хүлээн авч судалгаанд бүрэн хамрууллаа. Тус сард шинээр төрсөн 39 хүүхэд нэмж бүртгэсэн бол шүүхийн тэмдэгтийн хураамж болон бусад хөнгөлөлт эдлэх хүсэлтэй 22 иргэнд ӨМНС-аас гаргадаг амьжиргааны түвшний тодорхойлолтыг гарган өгсөн.

28 албан хаагч ургац хураалтын ажилд гар бие оролцлоо. Аймгийн ЗДТГ-аас санаачлан хэрэгжүүлсэн ургац хураалтын ажилд төрийн албан хаагч нарыг оролцох талаар санаачлагын хүрээнд Орхон суманд 28 албан хаагч 10 сарын 09-ний өдөр ажиллаж, ургац хураалтад оролцлоо. Мөн хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнд хамрагдаж буй 100 гаруй иргэн 2020.10.08-11-ний өдрүүдэд ургац хураалтын ажилд дэмжлэг үзүүлж ажилласан

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР